



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 26 өдөр

Дугаар A/168

Баян-Овоо

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ын 9.1, 9.2, 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн A/152 дугаар захирамжийн хүрээнд малчдын хоршоонд газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын төслийг үнэлж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Ш.Мөнххуяг	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн		
дарга	Б.Урансайхан	(Газрын даамал)
Гишүүд	А.Азжаргал	(Онон багийн Засаг дарга)
	Т.Оюун-Эрдэнэ	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
	М.Ариунгэрэл	(Төсөвт, төрийн сангийн мэргэжилтэн)

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Ш.Мөнххуяг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.МӨНХ-ОД



010000377